

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е16-PLN-0001-Е	Хувилбар: 1.3

“Оюу толгой” ХХК-ийн Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө

Хянан засварласан огноо: 2018 оны 7-р сарын 31

“Оюу толгой” төслийн Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны анхны төлөвлөгөөг (БОЯБҮАТ) “Оюу толгой” ХХК (ОТ) болон Төслийн санхүүжүүлэгчид Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд 2012 оны 8 дугаар сард баталж, олон нийтэд танилцуулсан. ОТ-н төлөвлөгөө, журамд орхигдуулсан зүйл, дутуу дулимаг мэдээллийг нөхөж шийдэх ажлыг удирдан чиглүүлэх зорилгоор тус төлөвлөгөөг боловсруулдаг. Шаардлага гарах бүрд Компанийн баримт бичиг хянах журмын дагуу төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилж байна. Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг анх боловсруулснаас хойш батлагдсан үйл ажиллагааг ОТ-н төлөвлөгөө (Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө ОТ-10-Е14-PLN-0003, Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө ОТ-10-Е14-PLN-0007), журамд (Газар хөндөх зөвшөөрлийн журам ОТ-10-Е14-PRC-0003, Ховор ургамал хамгаалах журам ОТ-10-Е14-PRC-007, Зэрлэг амьтан, амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүний хууль бус үйлдлийн журам ОТ-10-Е14-PRC-0005) нэгтгэн хэрэгжүүлж байна. 2018 онд хянаж засварласан Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны бүртгэл байдлаар ОТ-н портал дээр байршуулсан болно.

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
УДИРДЛАГА, НӨӨЦ					
		Одоогоор нээлттэй байгаа Сэдэв, Үйл ажиллагаа байхгүй.			
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ					
7	Ан амьтдын агаарын судалгаа	Биологийн олон янз байдлын хяналт, үнэлгээний төлөвлөгөөнд (БОЯБХҮТ) тодорхойлсны дагуу туурайтан амьтдын судалгаанд зориулж агаарын судалгааг тодорхой давтамжаар хийнэ.	(i) Ажлын удирдамжийг Санхүүжүүлэгчдэд танилцуулна (ii) Судалгаа хийнэ	(i) 2018 оны 4-р улирал (ii) 2019, түүнээс оноос хойш БОЯБХҮТ-нд тодорхойлсон давтамжаар	Ажлын удирдамжийг 2018 оны 4-р улиралд Санхүүжүүлэгчдэд хүргүүлсэн. Биологийн олон янз байдлын хяналт, үнэлгээний төлөвлөгөөг (БОЯБХҮТ) үзнэ үү.
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ					

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		Одоогоор нээлттэй байгаа Сэдэв, Үйл ажиллагаа байхгүй.			
УУРХАЙН ТАЛБАЙ ДАХЬ НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ					
		Одоогоор нээлттэй байгаа Сэдэв, Үйл ажиллагаа байхгүй.			
ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО					
		Одоогоор нээлттэй байгаа Сэдэв, Үйл ажиллагаа байхгүй.			
УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЖУРАМ					
		Одоогоор нээлттэй байгаа Сэдэв, Үйл ажиллагаа байхгүй.			
ХЭРЭГЖҮҮЛСЭН/ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА					
1	Хангалттай нөөц гаргах	Урт хугацаанд ОУСК-ын 6-р гүйцэтгэлийн стандарт, ЕСБХБ-ны 6-р гүйцэтгэлийн шаардлага, БОННУ-ний үүрэг амлалтаа биелүүлэх, биологийн олон янз байдалд эерэг нөлөө ахиу үзүүлэх зорилгоор ОТ ХХК Биологийн олон янз байдлын менежментийн хөтөлбөр, үүн дотор уурхайн талбайн хэмжээнд нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа, дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр, биологийн олон янз байдлын хяналт шинжилгээнд хангалттай нөөц, санхүүжилт хуваарилна.	Хэрэгжиж байгаа	Хэрэгжиж байгаа	ОТ-н портал дээрээс Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө, БОЯБХҮТ, Дүйцүүлэн хамгаалах удирдлагын төлөвлөгөөг (ДХУТ) үзнэ үү.
2	Биологийн олон янз байдлын судалгаа, хамгааллын байгууллагуудт ай урт	ОТ ХХК олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй, мэргэжлийн байгууллагуудтай албан ёсоор хамтран ажиллаж, ОТ-н биологийн олон янз байдлын удирдлагын хөтөлбөр боловсруулж, тохиромжтой бол	(i) Хамтын ажиллагааны гэрээний төсөл боловсруулсан	(i) Дууссан	GBC, SEA/WCS-тай байгуулсан гэрээг үзнэ үү.
			(ii) Хамтын ажиллагааны гэрээний төслийг Санхүүжүүлэгч зөвшөөрсөн	(ii) Дууссан	

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
	хугацаанд хамтран ажиллах	<p>хэрэгжүүлэх ба дараах ажлуудыг төлөвлөгөөнд тусгана:</p> <p>а) Биологийн олон янз байдлын урт хугацааны хяналт, үнэлгээ</p> <p>б) Тохиромжтой бол Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний тодорхой хэсгийг боловсруулж, хэрэгжүүлж, удирдан зохицуулах</p> <p>с) Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөө боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.</p> <p>Хамтын ажиллагааны хүрээнд ОТ-д мэдээлсний үндсэн дээр Санхүүжүүлэгчид зөвлөмж, санал хүсэх зорилгоор тухайн мэргэжлийн байгууллагатай бие даан харилцах боломжтой байхаар зохицуулна.</p> <p>ОТ хамтран ажиллах байгууллагатай хийсэн гэрээ, гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах бол эхлээд Санхүүжүүлэгчидтэй зөвлөлдөнө.</p>	<p>(iii) Хүлээн авсан саналуудыг Санхүүжүүлэгчдэд танилцуулах</p> <p>(iv) Хамтын ажиллагаа тогтоосон</p> <p>(v) Хамтран ажиллах гэрээ, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах бол Санхүүжүүлэгчидтэй зөвлөлдөнө</p>	<p>(iii) Дууссан</p> <p>(iv) Хэрэгжиж байгаа</p> <p>(v) Хэрэгжиж байгаа</p>	
3	Мэргэжлийн ур чадвар	<p>ОТ-н биологийн олон янз байдлын багт биологийн олон янз байдлын үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, ур чадвар, манлайлал үзүүлэх олон улсын тэргүүн туршлага эзэмшсэн, Монгол улсад байрлаж буй хувь хүн эсвэл бүлэг ахлах түвшний мэргэжилтнүүдийг Оюу толгойд бүтэн цагаар ажиллуулна. Тухайн ахлах мэргэжилтэн(үүд) нэг нэгээрээ эсвэл багаараа дараах чиглэлээр туршлагатай байна: биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр</p>	<p>(i) Ажилд авах үйл ажиллагааг эхлүүлэх</p> <p>(ii) Мэргэжилтэн(үүд)-ийн товч намтрыг Санхүүжүүлэгчдэд өгөх</p> <p>(iii) Хариуцсан мэргэжилтнийг Монголд байршуулах</p> <p>(iv) Санхүүжүүлэгчидтэй зөвлөлдөн жил тутмын</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) Дууссан</p> <p>(iii) Дууссан</p> <p>(iv) Жил бүр</p>	<p>ОТ-н ЭМААБОАБ-ын бүтцэд биологийн олон янз байдал хариуцсан ерөнхий зөвлөхийн орон тоог нэмсэн. Тухайн албан тушаалтан Монголд байрлан ажиллана. Чадавх бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулсан бөгөөд дээр дурдсан</p>

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		<p>боловсруулж хэрэгжүүлэх; биологийн олон янз байдлын хяналт, үнэлгээ; ижил түвшний хамрах хүрээ, нөхцөл байдал бүхий биологийн олон янз байдлын хөтөлбөрийн удирдлага.</p> <p>Ахлах мэргэжилтнүүдийн нэг (эсвэл ахлах мэргэжилтэн) нь биологийн олон янз байдлын хөтөлбөрийг удирдан зохицуулах албан тушаалыг (Хариуцсан мэргэжилтэн) хаших ба Оюу толгойн биологийн олон янз байдлын үндэсний мэргэжилтнүүд төслийн биологийн олон янз байдлын үүрэг амлалт хэрэгжүүлж, зохицуулах ур чадварыг бүрэн эзэмших хүртэлх шаардлагатай хугацаанд уг албан тушаалыг байлгана.</p> <p>Ур чадвар хөгжүүлэх үйл ажиллагааг Төслийн олон улсын биологийн олон янз байдлын байгууллагаас (2 дугаартай хэсэгт тодорхойлсноор) зөвлөмж авч, Санхүүжүүлэгчидтэй зөвлөлдөн жил бүр хянаж шалгана.</p>	<p>хяналтын үйл ажиллагаа явуулах</p> <p>(v) Ур чадвар хөгжүүлэх шалгуур боловсруулж, Санхүүжүүлэгчидтэй харилцан тохиролцох</p>	(v) Хэрэгжиж байгаа	ерөнхий зөвлөхийн үүрэг хариуцлагыг Биологийн олон янз байдал хариуцсан ахлах мэргэжилтэн хариуцан гүйцэтгэнэ.
4	Бие даасан шинжлэх ухааны зөвлөх байгууллага	<p>ОТ ХХК Удирдамжийн дагуу байгуулагдах бие даасан шинжлэх ухааны зөвлөлтэй (Зөвлөл) хамтран ажиллах ба уг зөвлөл нь ОТ-Гашуун сухайтын замын нөлөөлөл бууруулах үйл ажиллагаатай холбоотой техникийн асуултууд, Санхүүжүүлэгчидтэй тохиролцсоны дагуу бусад асуудлаар санал зөвлөгөө өгөх юм. Зөвлөлийн гишүүдийн тоо гурваас хэтрэхгүй.</p> <p>Зөвлөлийн тодорхой ажлуудыг нэг бүрчлэн ажлын даалгаварт тодорхойлно.</p>	<p>(i) Удирдамж, эхний даалгаврыг эцэслэн боловсруулж, ОТ, Санхүүжүүлэгчдээр батлуулна</p> <p>(ii) ОТ болон Санхүүжүүлэгчид эхний даалгаврын зөвлөлд орох гишүүдийг баталж харилцана</p> <p>(iii) ОТ Санхүүжүүлэгчидтэй тохирсны дагуу Зөвлөлийн замын</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) Дууссан</p> <p>(iii) Дууссан</p>	<p>ОТ-Гашуун сухайт чиглэлийн замын нөлөөлөл бууруулах стратегийн талаар хөндлөнгийн шинжлэх ухааны зөвлөх байгууллагаас гаргасан тайлан (2017).</p>

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		<p>Дээр дурдсаны дагуу Зөвлөлийн эхний зорилго нь ОТ – Гашуун сухайтын замын нөлөөлөл бууруулах стратегитай холбоотой техникийн асуултуудад санал өгөх ажил байна.</p> <p>Шаардлагатай бөгөөд тохиролцсон ирээдүйн даалгаврын дагуу Зөвлөлөөс 6-р гүйцэтгэлийн стандарт, 6-р гүйцэтгэлийн шаардлагад нийцүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээний талаар шинжлэх ухааны бие даасан зөвлөмжийг Санхүүжүүлэгчид болон ОТ-д өгнө.</p> <p>Зөвлөлийн илрүүлсэн зүйлсийг олон нийтэд танилцуулна.</p>	<p>нөлөөлөл бууруулах тайланг танилцуулна (зүйл 13)</p> <p>(iv) Зөвлөлийн замын нөлөөллийн стратегийн хяналтаас гарсан, ОТ болон Санхүүжүүлэгчид зөвшөөрсөн арга хэмжээг ОТ-н удирдлагын төлөвлөгөөнүүдэд тусгана</p> <p>(v) Цаашид гүйцэтгэх ажил, ажлын даалгавар, зөвлөлийн гишүүд, тайлангийн нийтлэл, арга хэмжээг ОТ Санхүүжүүлэгчидтэй тохиролцоно</p>	<p>(iv) Дууссан</p> <p>(v) Дууссан</p>	
5	Хяналт, үнэлгээний төлөвлөгөө	<p>ОТ ХХК 6-р гүйцэтгэлийн стандартын аравдугаар мөр, 6-р гүйцэтгэлийн шаардлагын наймдугаар мөрийн дагуу урт хугацаанд төслийн нийцлийг хангахуйц ховор уугуул төрөл зүйлүүдэд зориулсан Биологийн олон янз байдлын хяналт, үнэлгээний төлөвлөгөө (БОЯБХҮТ) боловсруулна. Тус төлөвлөгөөнд ОТ-н талуудын оролцоо болон 6-р гүйцэтгэлийн стандартын есдүгээр мөр, 6-р гүйцэтгэлийн шаардлагын зургаадугаар мөрт төсөл нийцэж буйг тодорхойлоход хангалттай байхаар биологийн олон янз байдлын бусад чухал төрөл зүйлүүдийг тусгана. Ховор уугуул төрөл зүйл, биологийн чухал ач холбогдолтой олон янз байдлын хувьд урт хугацааны</p>	<p>(i) БОЯБХҮТ-ний төслийг Санхүүжүүлэгчдэд өгч хянуулна</p> <p>(ii) Төлөвлөгөөний эцсийн хувилбарыг танилцуулна</p> <p>(iii) Төлөвлөгөөг тохиролцсон хэлбэрээр нийтэд танилцуулна</p> <p>(iv) БОЯБХҮТ хэрэгжүүлж, үр дүнг жил бүр нийтэлнэ (Санхүүжүүлэгчидтэй тохирсон хэлбэрээр)</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) Дууссан</p> <p>(iii) Дууссан</p> <p>(iv) Хэрэгжиж байгаа</p>	<p>ОТ-н цахим хуудаснаас БОЯБХҮТ-ний сүүлийн хувилбарыг үзнэ үү.</p>

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		нийцэл, статистикийн үүднээс ач холбогдолтой байхаар холбогдох хэмжих үзүүлэлтүүдийг хяналт, үнэлгээний төлөвлөгөөнд тусгана.			
6	Экосистемийн үйлчилгээний мониторинг	Оюу толгой компани Экосистемийн үйлчилгээний ажлын хэсгээр дамжуулан нэн чухал экосистемийн үйлчилгээнд зориулсан олон чиглэлийн хяналт, үнэлгээний хөтөлбөр боловсруулна. Хөтөлбөрийг одоогийн усны мониторингийн хөтөлбөр, чухал экосистемийн үйлчилгээний мониторинг, Бор Овоогийн ундаргын мониторингийн үйл ажиллагаанд суурилж, эдгээрийн бүрдэл хэсгүүдийг нэгтгэнэ. Уг хөтөлбөрийг байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд хамтран боловсруулах ба нийгмийн мониторингийн үйл ажиллагаатай нэгтгэнэ. Экосистемийн үйлчилгээний хяналт, үнэлгээний хөтөлбөрт дасан зохицох удирдлагын стратеги болон урт хугацаанд нийцэл хангахад шаардлагатай холбогдох хэмжүүр, үзүүлэлтүүдийг багтаана.	(i) Одоогийн ургамал, бэлчээрийн чанар, экосистемийн үйлчилгээний нөлөөлөл бууруулах стратегид орхигдсон асуудлын/ зөрүү шинжилгээ хийх	(i) Дууссан	Экосистемийн үйлчилгээний ажлын хэсэг (ЭҮАХ) байгуулсан. Жил бүр Экосистемийн үйлчилгээний хяналт, үнэлгээний төлөвлөгөөний тайлан гаргаж байгаа.
			(ii) Санхүүжүүлэгчдээр хяналт, үнэлгээний хөтөлбөрийн төслийг хянуулна (хамааралтай бол тусгай төлөвлөгөө)	(ii) Дууссан	
			(iii) Хяналт, үнэлгээний хөтөлбөрийг эцсийн байдлаар боловсруулж, хэрэгжүүлж эхлэх (хамааралтай бол тусгай төлөвлөгөө)	(iii) Хэрэгжиж байгаа	
8	Дүйцүүлэн хамгааллын удирдлагын хөтөлбөр, төлөвлөгөө	ОТ одоо мөрдөж байгаа Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө, Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний ном, Санхүүжүүлэгчдийн шаардлагын бичиг баримтуудад суурилсан дүйцүүлэн хамгааллын удирдлагын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт дараах зүйлсийг хамарсан Дүйцүүлэн	(i) (i) Одоогийн дүйцүүлэн хамгаалах туршилтын ажлуудыг тодорхойлж үнэлээ, шинэ мэдээг Санхүүжүүлэгчдэд хүргэнэ	(i) Дууссан	ДХУТ-г компанийн баримт бичиг хянах журмын дагуу боловсруулсан бөгөөд тогтмол шинэчилж байгаа. Дүйцүүлэн хамгаалах туршилтын ажлын үйл явцын талаар
			(ii) ДХУТ-ний төслийг БОНХЗ, Санхүүжүүлэгчдэд хүргэн хянуулах, дүйцүүлэн хамгаалах санхүүжилтийн	(ii) Дууссан	

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		хамгааллын удирдлагын төлөвлөгөө (ДХУТ) орно: а) дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг дэмжих ОТ-н сонгосон санхүүжилтийн тогтвортой механизм б) 2012 онд нийтэлсэн ОТ-н дүйцүүлэн хамгааллын стратегид суурилсан, ОТ-н төлөвлөлтийн хугацаанд тохирсон урт хугацааны төсвийн төлөвлөгөө (ж.нь тухайн жилийн, 2 болон 5 жилийн төлөвлөгөө). Хөтөлбөрийн нийт зардлын тооцоог шинэчлэх ба с) цаашид жил бүр шинэчлэхдээ холбогдох ЦЭН тооцоонд үндэслэнэ д) Хамгаалах үйл ажиллагаагаар дамжуулан биологийн олон янз байдалд өндөр үр ашиг авчрахад хангалттай хэмжээнд төслийн үйл ажиллагаанаас нэн чухал төрөл зүйлүүдэд нөлөөлөх нөлөөг бууруулах тухайн жилийн болон урт хугацааны гол хэмжүүрүүд тодорхойлох ба ингэснээр ОУСК-ийн 6-р гүйцэтгэлийн стандарт, ЕСБХБ-ны 6-р гүйцэтгэлийн шаардлагад урт хугацаанд нийцүүлэх, мөн уурхайн ашиглалтын хугацаанд Цэвэр эерэг үр ашиг авчрах зорилгод хүрнэ.	боломжит хувилбаруудыг багтаана (iii) ДХУТ-ний эцсийн хувилбарыг БОНХЗ, Санхүүжүүлэгчдэд хүргүүлж хянуулж батлуулна. Эцсийн хувилбар нь ДХУТ-ний агуулгад орсон сэдвүүдийг тусган, БОЯБҮАТ, ГС6, ГШ6-д тусгасан шаардлагуудыг хангана (iv) ОТ, Санхүүжүүлэгчдийн зөвшөөрсөн ДХУТ-г олон нийтэд тэдний зөвшөөрсөн хэлбэрээр танилцуулна	(iii) Дууссан (iv) Дууссан	жил бүр тайлан гаргаж байгаа. Гуравдагч талын гүйцэтгэгч ЦЭН, түүний үнэлгээг тогтмол хийж шинэчлэн, эдгээрийг дүйцүүлэн хамгаалах ажлын явцыг үнэлэхэд ашиглаж байна.

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
9	Цэвэр эерэг нөлөөллийн тооцоолол	Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөө (ДХУТ), дасан зохицох удирдлагатай нийцүүлэх зорилгоор төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах ажлын хүрээнд ОТ ЦЭН тооцоог шинэчилж, үр дүнг Санхүүжүүлэгчдэд хүргэнэ.	(i) 2015 оны дүйцүүлэн хамгааллын үйл ажиллагааны ЦЭН тооцоог шинэчилж, үр дүнг Санхүүжүүлэгчдэд хүргэнэ	(i) Дууссан	БОЯБУТ-нд заасны дагуу ЦЭН таван жил тутам шинэчилж байна. Энэ тухай Санхүүжүүлэгчид танилцуулж, ОТ-н цахим хуудсанд байрлуулдаг.
			(ii) ДХУТ-тай холбоотойгоор ЦЭН тооцоог шинэчилнэ	(ii) Дууссан	
			(iii) Шинэчилсэн ЦЭН тооцоог олон нийтэд танилцуулна	(iii) Дууссан. Үүнээс хойш ОТ Санхүүжүүлэгчтэй тохирсон хугацаанд хийнэ	
10	Дүйцүүлэн хамгаалах ажлын санхүүжилт	Санхүүжүүлэгчидтэй тохиролцсоны дагуу дүйцүүлэн хамгааллын санхүүжилтийн тогтолцоог (8-р зүйлд дурдсанаар) хуулийн үүднээс баталгаажуулж, дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөрийн урт хугацааны хэрэгжилтийг хангахад шаардагдах бүх удирдлага, захиргааны тогтолцоог бий болгоно.	Тогтолцоо байгуулна	Байгаль орчин, нийгмийн гэрчилгээ олгох үед эсвэл олгохын өмнө	Байгаль орчны үйл ажиллагааны төсвөөс биологийн олон янз байдлын төсвийг тусад нь бүртгэх зардлын төв гаргасан.
11	Галбын говийн Шувуудад чухал бүс (ШЧБ)-д ирээдүйд явуулах барилга угсралт, засварын ажил	ОТ компани яаралтай, цаг хугацааны хувьд онцгой нөхцөл шаардсан засварын ажлаас бусад нөхцөлд Галбын говийн ШЧБ-д Жороо тоодгийн үржлийн хугацаанд (4 сарын 15-аас 6 сарын 30) барилга угсралт, засварын ажил явуулахаас зайлсхийнэ.	(i) Үйл ажиллагааны шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөнд тус зайлсхийх арга хэмжээг тусгана	(i) Дууссан	Галбын говийн ШЧБ-д одоогийн байдлаар барилга угсралт, засварын ажил хийгдээгүй. Газар хөндөлтийн хяналтын үйл явцын дагуу үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байгаа.
			(ii) ГХЗ-ийн үйл явц, уурхайн талбай дахь мониторингийн хүрээнд хэрэгжилтийг баталгаажуулна	(ii) Хэрэгжиж байгаа	

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
12	Цахилгааны шугамын тусгаарлалт	Дунд, бага хүчдэлийн цахилгааны шугамын шон, төгсгөл, дэд станц, өндөр хүчдэлийн шонгуудад тусгаарлагч суурилуулна.	(i) мэргэжлийн зөвлөх дунд/бага хүчдэлийн тусгаарлалтын ажилтай холбоотой эрсдэлийн үнэлгээг эхэлнэ	(i) Дууссан	Эрсдэл багатай шугамуудаас бусдад тусгаарлагч суурилуулсан. ОТ-н Амьтан судлалын баг цахилгааны шугамд сар бүр үзлэг шалгалт хийж, тусгаарлагч болон бусад шувуу хамгаалах үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж байгаа. Энэ тухай жилийн тайлан, БОЯБУТ-ний тайланд хураангуйлан оруулсан.
			(ii) мэргэжлийн зөвлөх дунд/бага хүчдэлийн тусгаарлалтын ажилтай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийж дуусгана	(ii) Дууссан	
			(iii) холбогдох хангамж/суурилуулалтын ажлыг эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу эхлүүлнэ	(iii) Дууссан	
			(iv) холбогдох хангамж/суурилуулалтын ажлыг эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу хийж дуусгана.	(iv) Дууссан	
13	Замын нөлөөлөл бууруулах	Төсөл гүйцэтгэгч ОУСК-ын ГС6, ЕСБХБ-ны ГШ6, ОТ-н эерэг нөлөө ахиу үзүүлэх үүрэг амлалт хэрэгжүүлэхийн тулд ОТ компани: (i) дараах хэсгүүд болон эдгээрээр хязгаарлагдахгүй ОТ-ГС замын нөлөөлөл бууруулах стратеги боловсруулж хэрэгжүүлнэ: а) замын хаалт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлалт, b) бүс нутгийн хэмжээний тогтвортой хөгжилтэй хамааралтай зарим нөлөөлөл бууруулах арга хэмжээнд оролцох бүс нутгийн байгууллагуудтай албан ёсоор хамтран ажиллах, c) ОТ-ГС зам, ОТ-н бус замын хөдөлгөөнд хяналт тавих, амьтдад	(i) Draft strategy provided for Lender review and comment	(i) Дууссан	Дээрээс 4-р зүйлийг харна уу. ОТ-ГС замын нөлөөлөл бууруулах стратегийн анхны төслийг Бие даасан зөвлөлөөр 2017 онд хянуулсан. ОТ-ГС замын нөлөөлөл бууруулах стратегийг хянуулсны дараа Зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийг
			(ii) Strategy reviewed by the Independent Panel	(ii) Дууссан	
			(iii) Commence implementation of strategy	(iii) Хэрэгжиж байгаа	

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		<p>учруулж буй нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх;</p> <p>(ii) Замын нөлөөлөл бууруулах стратегийг бие даасан шинжлэх ухааны зөвлөлөөр хянуулна,</p> <p>(iii) Зөвлөлийн хянаснаар ОТ болон Санхүүжүүлэгчдийн харилцан тохирсон арга хэмжээг стратегид оруулна (4 дүгээр зүйлийг харах)</p>			тусган, 2018 оны 3-р сард бэлэн болгосон.
14	Зөвшөөрөлгүй замаар зорчих	<p>Оюу толгой компани:</p> <p>(i) одоо явуулж буй оролцогч талуудтай хамтран ажиллахтай холбоотой мэдээлэл, боловсрол олгох ажлын хүрээнд замгүй газраар жолоодох, үүний улмаас айл өрх, амьтдын хамгаалалд хэрхэн нөлөөлөх талаар материал боловсруулж тарааж,</p> <p>(ii) замгүй газраар жолоодохтой холбоотой шаардлагуудыг гэрээт байгууллагын менежментийн хөтөлбөр, шинэ болон гэрээт ажилчдын танилцуулах сургалтын хөтөлбөрт оруулна.</p>	<p>(i) Мэдээллийн материалуудыг БОНХЗ-ийн мониторингийн үйл ажиллагаанд оруулна</p> <p>(ii) Замгүй газраар тээврийн хэрэгсэл жолоодохын үр дагаврыг үзүүлсэн материалыг үндсэн болон гэрээт ажилчдын сургалтад оруулна</p>	<p>(i) 2016, аудитын хуваарийн дагуу хэрэгжиж байгаа</p> <p>(ii) Дууссан</p>	<p>Уурхайн талбайн ерөнхий болон танилцуулах сургалт, жолооч нарын сургалтын материалууд.</p> <p>Нарядын/Ажил эхлэхийн өмнөх уулзалт хурлын үеэр тодорхой давтамжаар шалгалт хийдэг.</p> <p>Гэрээнд замгүй газраар тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглосон заалт нэмсэн.</p>
15	Биологийн олон янз	<p>ОТ компани:</p> <p>(i) барилгын болон ашиглалтын ажилтнуудад (оператор, гэрээт)</p>	<p>(i) Санхүүжүүлэгчдэд сургалтын багц хүргэнэ</p>	<p>(i) Дууссан</p>	<p>Сургалтын материал боловсруулж, уурхайн талбайн</p>

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
	байдлын сургалтын багц	<p>зориулсан жолоочийн мэдлэг, дүрэм, хог хаягдлын журам, ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдэл зэрэг биологийн олон янз байдлын сэдвүүдээр сургалтын багц боловсруулна.</p> <p>(ii) Голлох биологийн олон янз байдалтай холбоотой сэдвүүдийг өглөөний хурлын ярилцах сэдэвт оруулна.</p> <p>(iii) Одоогийн танилцуулах сургалтын хөтөлбөрийг дахин хянаж, холбогдох шаардлагуудыг оруулсан эсэхийг бататгана.</p>	(ii), (iii)-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх	(ii), (iii)-т заасан арга хэмжээг хэрэгжиж байгаа	<p>ерөнхий болон танилцуулах сургалтад оруулсан.</p> <p>Нарядын/Өглөөний хурлын ЭМААБОАБ-ын сарын үйл ажиллагааны сэдэвт биологийн олон янз байдлын сэдвүүд нэмсэн.</p> <p>ЭМААБОАБ-ын сэдэвт дэмжлэг болгож “Ажилчдын дуу хоолой”-гоор гаргах видео.</p>
16	Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө	<p>ОТ компани (i) уурхайн талбай дахь биологийн олон янз байдлын нөлөөлөл бууруулах, (ii) дүйцүүлэн хамгааллын удирдлагын хөтөлбөр, төлөвлөгөө, (iii) бүс нутгийн хэмжээний төлөвлөлттэй холбоотой хамтын ажиллагааг хамарсан зорилтот Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулна.</p>	Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг шинэчилнэ	Дууссан	<p>ОТ-н Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө.</p> <p>ОТ-н Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний хавсралт болох Биологийн олон янз байдлын хамгаалалд талуудын оролцоог хангах төлөвлөгөө</p>
17	Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрт	<p>ОТ компанийн биологийн олон янз байдлын хөтөлбөр нь бүс нутгийн хэмжээний төлөвлөлтийн асуудлыг</p>	ОТ-н явуулж буй талуудын оролцоог хангах үйл ажиллагааг	Жил бүрийн мониторингийн тайлан болон БОНХЗ	16-р зүйлийг харна уу

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
	талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангах	тусгасан, Монгол улсын голлон анхаарах хамгаалах чиглэл болон оролцогч талуудын сонирхолд нийцсэн, урт хугацаанд техник болон бодлогын талаас тогтвортой байх нөхцөлийг хангах зорилгоор оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж, харилцан зөвшилцөнө. Үүнд Монгол улсын засгийн газар, бүс нутгийн байгууллага, уул уурхайн бусад компани, төслийн нөлөөлөлд өртсөн ард иргэд, сонирхогч талууд (Гурван талт зөвлөл: орон нутгийн малчид, орон нутгийн удирдлага болон ОТ)-тай хамтран ажиллах үйл явц багтана.	Санхүүжүүлэгчдэд өгдөг тайланд тусгаж (ж.нь жилийн мониторингийн тайлан, байгаль орчин, болон нийгмийн хөндлөнгийн үнэлгээний тайлан), уулзалтын тов, хурлын тэмдэглэлийг Санхүүжүүлэгчдэд өгөх	тайланд тусгана	
18	Нөхөн сэргээлт	<p>ОТ компани Газар, Биологийн олон янз байдлын багийн оролцоотойгоор Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (ГХХНСТ) боловсруулах ба дараах журмуудыг багтаасан байна:</p> <p>а) Шинэчилсэн Газар хөндөлтийн журам;</p> <p>б) Шинэчилсэн Шимт хөрстэй ажиллах журам;</p> <p>с) Шинэчилсэн Техникийн нөхөн сэргээлтийн журам;</p> <p>д) Биологийн нөхөн сэргээлтийн журам.</p> <p>БОНХЗ нь ГХХНСТ-г Санхүүжүүлэгчдийн шаардлагад нийцсэн бөгөөд БОННУ, БОНУТ-д тусгасан холбогдох үүрэг амлалтуудыг тусгасан болохыг шалгаж баталгаажуулна.</p>	<p>(i) ГХХНСТ-ний төслийг БОНХЗ-өөр хянуулж, санал авна</p> <p>(ii) БОНХЗ-өөр ГХХНСТ-ний эцсийн хувийг хянуулж санал авах; ГХХНСТ-нд холбогдох бүх үүрэг орж Санхүүжүүлэгчдийн шаардлагад нийцсэн болохыг БОНХЗ тэдэнд батлах.</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) Дууссан</p>	<p>Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө</p> <p>Газар хөндөх зөвшөөрлийн журам</p> <p>Шимт хөрстэй харьцах журам</p> <p>Техникийн нөхөн сэргээлтийн журам</p> <p>Биологийн нөхөн сэргээлтийн журам</p> <p>Ховор ургамал хамгаалах журам</p>

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
19	Байгалийн ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдэл	<p>ОТ компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль бус ан агнуур, ургамал түүх ажиллагааг хянах зорилгоор дараах арга хэмжээ авна:</p> <p>(i) Дараах нөхцөлийг хангасан ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийг зохицуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ:</p> <p>(a) нисэх онгоц, тээврийн хэрэгсэл, ачааны үзлэг, улирлын үзлэг шалгалтын доод хязгаарыг заасан шаардлага заах;</p> <p>(b) шалгаж баталгаажуулах арга замыг бүрдүүлэх зорилгоор үзлэгийн шаардлагыг тодорхой заах;</p> <p>(c) үндсэн болон гэрээт ажилтан ан амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн хууль бусаар авч явсан тохиолдолд зохих арга хэмжээ авах замаар журмын хэрэгжилтийг хангах;</p> <p>(ii) Бүх үндсэн болон гэрээт ажилтныг журмын талаарх сургалт, кэмп, нисэх буудлын ажилтнуудыг хэрхэн хууль бус амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн таних талаар сургалтад хамруулна.</p> <p>(iii) Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө болон холбогдох үйл ажиллагаагаар дамжуулан уг асуудлын тухай ойлголт, мэдлэгийг сайжруулна.</p>	<p>(ia) Шинэчилсэн журмыг хянуулахаар БОНХЗ-д хүргүүлнэ</p>	(ia) Дууссан	<p>Бүх ажилтан хамрагддаг уурхайн талбайн ерөнхий болон танилцуулах сургалтын материал.</p> <p>Хууль бус ан агнуур, амьтны гаралтай бүтээгдэхүүн, ургамлын менежментийн журам.</p> <p>ЭМААБОАБ-ын нарядын/өглөөний хурлын сэдэв.</p> <p>Хулгайн антай тэмцэх үйл ажиллагааг иргэдэд сурталчлах.</p>
		<p>(i) Дараах нөхцөлийг хангасан ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийг зохицуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ:</p>	(ib) Журмыг эцэслэнэ	(ib) Дууссан	
		<p>(ii) Шаардлагатай сургалт явуулна</p>	(ii) Хэрэгжиж байгаа		
		<p>(iii) Оролцогч талуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ</p>	(iii) Хэрэгжиж байгаа		

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
	Шувуу үргээгч	<p>ОТ компани:</p> <p>(i) Хятадын хилээс Оюу толгой уурхай хүрэх өндөр хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суулгана.</p> <p>(ii) Гүний хоолойн цооногийн талбайгаас Оюу толгой уурхай хүрэх дунд хүчдэлийн цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулна.</p> <p>(iii) Оюу толгойн уурхайгаас Ханбогд сумын төв хүрэх дунд хүчдэлийн цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулна.</p> <p>(iv) (шувуу үргээгч гэдэгт “Bird Mark – Model BM-AG (After Glow)” загвар, “Swan” загварын мушгиа шувуу үргээгч орно).</p>	<p>(ia) Өндөр хүчдэлийн цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулж эхлэх</p> <p>(ib) Өндөр хүчдэлийн цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулж дуусгах</p> <p>(iia) Дунд хүчдэлийн цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулж эхлэх</p> <p>(iib) Дунд хүчдэлийн цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулж дуусгах</p> <p>(iii) Ханбогд сумын төв хүрэх дунд хүчдэлийн цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулж дуусгах</p>	<p>(ia) Дууссан</p> <p>(ib) Дууссан</p> <p>(iia) Дууссан</p> <p>(iib) Дууссан</p> <p>(iii) Дууссан</p>	<p>Цахилгааны шугамд шувуу үргээгч суурилуулсан.</p> <p>Энд зааснаас гадна цахилгааны шинэ шугамд шувуу үргээгч суурилуулсан.</p> <p>ОТ-н Амьтан судлалын баг шувууд цахилгааны шугам мөргөсөн эсэхэд сар бүр хяналт тавьдаг. Энэ тухай жилийн тайлан, БОЯБУТ-ний тайланд хураангуйлан оруулсан.</p>
	Шугам татах	<p>Үржлийн улирлын үеэр (4 сарын 15-аас 6 сарын 30) бөөгнөрсөн Жороо тоодгийн сүрэгт бага нөлөөлөл үзүүлэх үүднээс Галбын говийн Шувуудад чухал бүсэд цахилгааны шугам татах үйл ажиллагааг аль болох хурдан гүйцэтгэж, 2012 оны 4 дүгээр сард багтаахын тулд ОТ боломжит бүх арга хэмжээ авна.</p> <p>Бүх арга хэмжээ авсны дараа шугам татах ажиллагааг тодорхой тооны хязгаарласан цэгүүдийн хооронд гүйцэтгэх ба уг цэгүүдэд эхлээд тоодог байгаа эсэхийг шалгана. Шугам татах ажлын үеэр жороо тоодог судлаач ажиллаж, жороо тоодгийн үржлийн талбай байгаа эсэхийг тогтооно.</p>	<p>(i) Шугам татах ажиллагааг эхлүүлнэ</p> <p>(ii) ШЧБ-эд шугам татах 2 баг ажиллуулж, тухайн бүс дэх ажлыг аль болох эрт дуусгана</p> <p>(iii) Шугам татаж дуусгана</p> <p>(iv) Холбогдох удирдлагын төлөвлөгөөг шинэчилнэ</p> <p>(v) Гэрээт байгууллагын гүйцэтгэлийн талаар Санхүүжүүлэгчдэд мэдээлнэ</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) Дууссан</p> <p>(iii) Дууссан</p> <p>(iv) Дууссан</p> <p>(v) Дууссан</p>	<p>Шугам татсан.</p> <p>Галбын говийн ШЧБ-эд шинээр үйл ажиллагаа явуулах шаардлага гарвал ГХЗ-ийн журам, үйл явцын дагуу хянуулж нөлөөлөл бууруулах арга хэмжээ боловсруулна (дээрх 11-р зүйлийг харна уу).</p>

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		Тогтоосон бол ОТ компани тоодгийн мэргэжилтэнтэй холбоо тогтоож, нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх хамгийн тохиромжтой арга хэмжээг тодорхойлно.			
	Малын гарам	Оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр ОТ компани: (i) ОТ-Гашуун сухайт чиглэлийн зам дагуу тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулах хэрэгсэл, бусад инженерийн аргачлал ашиглан мал замаар гарах боломж бүрдүүлсэн гарц байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулна. (ii) Гарц байгуулна.	(i) Эцсийн байдлаар боловсруулсан ажлын төлөвлөгөөг Санхүүжүүлэгчдэд танилцуулна (iia) Ажлыг эхлүүлнэ (iib) Ажлыг дуусгана	(i) Дууссан (iia) Дууссан (iib) Дууссан	ОТ-Гашуун сухайт чиглэлийн зам дагуу гарц байгуулсан.
	Замын тэмдэг	ОТ компани ОТ-Гашуун сухайт, ОТ-Ханбогд, ОТ-цооногийн талбай чиглэлийн зам дагуу мал, амьтан мөргөх эрсдэлтэйг анхааруулсан, тухайн орчинд зэрлэг амьтан байж болохыг сануулсан замын тэмдэг суурилуулна. Тэмдэг нь “Өрнөдийн тээврийн институт” байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцсэн байна.	Замын тэмдэг суурилуулна	Дууссан	Замын тэмдэг суурилуулсан. Хулангийн хүзүүвчний мэдээлэл шалгах жилийн үнэлгээний ажлын хүрээнд замын тэмдэг, тэдгээрийн байршлыг шалгадаг.
	Голын/Сайрын дагуух заг, хайлаасан шугуй	Эдгээр чухал газруудад үзүүлж буй нөлөөллийг бууруулах зорилгоор одоо хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чанарт үнэлгээ хийж, боломжтой нөхцөлд цэвэр алдагдалд хүрэхээс зайлсхийнэ (байгалийн орчин). Мөн тодорхойлсон нэмэлт арга хэмжээг уурхайн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө, Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөөнд тусган оруулна.	(i) ОТ-н үнэлгээний үр дүнг Санхүүжүүлэгчдэд танилцуулна (ii) ОТ-н үнэлгээнд үндэслэн нэмэлт арга хэмжээг Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө, Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөөнд тусгана.	(i) Дууссан (ii) Дууссан	ГХЗ-ийн дагуу заг, хайлаасанд шууд нөлөө үзүүлж байгаа эсэхийг хянаж бүртгэдэг. Гол биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд заг, хайлаасны

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
					хяналт шинжилгээ хийж байгаа.
	ЦЭН протокол, хяналтын комисс (ii)	ОТ компани Байгаль хамгаалах олон улсын холбооны баталсан Цэвэр эерэг нөлөөний протоколд оролцож, Хяналтын комиссын баг (ЦЭНП, ХКБ)-тай хамтран ажиллах ба баг нь "Рио тинто", ОТ компанийн ЦЭН үзүүлэх зорилгын хэрэгжилтийг баталгаажуулах бие даасан үйл ажиллагааг боловсруулж, шалгаж, хэрэгжүүлнэ.	(iia) Төсөлд зориулсан ажлын даалгавар боловсруулж, Санхүүжүүлэгчдэд хүргэнэ (iib) ОТ-н ЦЭНП, ХКБ-ийг баталгаажуулах туршилтын хөтөлбөр эхэлнэ	(iia) Дууссан (iib) Дууссан	Цэвэр эерэг нөлөөллийн хяналтын тайлан: "Оюу толгой" ХХК (БХОУХ 2013)
	2012 онд хийсэн хээрийн суурь судалгааны хөтөлбөр – Жороо тоодог	ОТ компани мониторингийн хөтөлбөрийнхөө хүрээнд Жороо тоодгийн хээрийн биологийн төрөл зүйлийн суурь судалгааг эхлүүлнэ. Суурь судалгаа нь Биологийн олон янз байдлын хяналт, үнэлгээний хөтөлбөрийн зорилго зорилтод нийцсэн байна.	(i) Ажлын удирдамжийг ОУСК-аар хянуулна (ii) Багууд ажлаа эхэлнэ	(i) Дууссан (ii) Дууссан	Амьтан судлалын баг сар бүрийн ан амьтдын хяналт шинжилгээний хүрээнд жороо тоодгийн хяналт шинжилгээг уурхайн талбайд хийдэг. ЗАСХТ бүс нутгийн/улсын хэмжээнд жороо тоодгийн популяцын судалгааг 2018-2020 оны хооронд хийнэ.
	2012 онд хийсэн хээрийн суурь судалгааны хөтөлбөр – том биет туурайтан амьтад	ОТ компани мониторингийн хөтөлбөрийнхөө хүрээнд том биет туурайтан амьтдын хээрийн биологийн төрөл зүйлийн суурь судалгааг эхлүүлнэ. Суурь судалгаа нь Биологийн олон янз байдлын хяналт, үнэлгээний хөтөлбөрийн зорилго зорилтод нийцсэн байна.	(i) Газраар хийх туурайтан амьтдын судалгааны ажлын удирдамжийг ОУСК-аар хянуулна (ii) Баг байгуулж, судалгааг эхлүүлнэ	(i) Дууссан (ii) Дууссан	Суурь судалгаа хийсэн. ОТ-н Амьтан судлалын баг сар бүр туурайтан амьтдын хяналт шинжилгээ хийдэг.

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
					Бүс нутгийн туурайтан амьтдын судалгааны талаар Гол биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний хөтөлбөрт оруулсан.
	Ашиглалтын үе шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө	ОТ компани үндсэн болон гэрээт ажилтнууд, туслан гүйцэтгэгчдийн бүх үүрэг хариуцлагыг тусгаж, уурхайн талбайд явагдах биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл бууруулах бүх үйл ажиллагааг багтаасан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн салбарын шилдэг туршлагыг ашигласан Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын төлөвлөгөө боловсруулж, Санхүүжүүлэгчдээр хянуулна. Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөнд тухайн үе шатанд хийгдэх барилга угсралтын ажилтай холбоотой үүрэг амлалт, арга хэмжээг тусгана. Хамааралтай бол биологийн олон янз байдалтай холбоотой үүрэг амлалтуудыг Тээврийн удирдлагын төлөвлөгөө, Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө, Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө, Шилжин ирэх хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө зэрэг бусад холбогдох Удирдлагын төлөвлөгөөнд тусгана.	(i) Төлөвлөгөөний төслийг Санхүүжүүлэгчдээр хянуулна (ii) Эцсийн төлөвлөгөөг Санхүүжүүлэгчдэд өгнө	(i) Дууссан (ii) Дууссан	БОЯБУТ
	Ашиглалтын үе шатны Биологийн олон янз байдлын	“Рио тинто”-гийн Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний явц эцэслэсний дараа ОТ компани Ашиглалтын шатны Биологийн олон янз	Шинэчилсэн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөг Санхүүжүүлэгчдээр хянуулна	Дууссан	БОЯБУТ БОЯБУТ-г компанийн баримт бичиг хянах журмын дагуу

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
	удирдлагын төлөвлөгөө	байдлын удирдлагын төлөвлөгөөгөө шинэчилнэ.			тогтмол шинэчилж байгаа.
	Ашиглалтын үе шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө	БОНХЗ, Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө боловсруулахад оролцоогүй биологийн олон янз байдал хариуцсан нэг түнш Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (БОЯБУТ), “D” хавсралт (Биологийн олон янз байдлын үүрэг амлалтын бүртгэл)-ыг хянаж шалган, БОННУ-нд тусгасан биологийн олон янз байдлын бүх үүрэг амлалт Ашиглалтын үе шатны удирдлагын төлөвлөгөөнүүд, бусад холбогдох баримт бичигт тусгасан эсэхийг шалгаж баталгаажуулна. Хэрэв ямар нэг дутагдал илэрвэл ОТ уг дутагдлыг арилгаж, холбогдох Ашиглалтын шатны удирдлагын төлөвлөгөөнүүдийг шинэчилнэ.	(i) БОЯБУТ, “D” хавсралтыг БОНХЗ-өөр хянуулна. БОНХЗ хянаж дуусаад үр дүнг Санхүүжүүлэгчдэд танилцуулна. (ii) БОНХЗ-ийн хяналтын үр дүнгээс хамаарч шаардлагатай бол БОЯБУТ-г шинэчилнэ.	(i) Дууссан (ii) Дууссан	БОЯБУТ-г эцэслэн гаргахаас өмнө Санхүүжүүлэгч, БОНХЗ-өөр хянуулж шалгуулсан.
	Байгууллагын бүтэц	ОТ компани нийгэм-экологийн, тэр дундаа дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг Ашиглалтын үе шатанд хариуцан ажиллах байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд (Экосистемийн үйлчилгээний групп) томилон ажиллуулна.	Мэргэжлийн олон чиглэлийн баг бүрдүүлж, Ажлын удирдамж боловсруулан Санхүүжүүлэгчдэд өгнө	Дууссан	ЭҮАХ
	Экосистемийн үйлчилгээний групп	ОТ компани Санхүүжүүлэгчдийн холбогдох шаардлагын дагуу экосистемийн үйлчилгээний удирдлага, БОЯБУТ-д заасан үүрэг амлалтын хэрэгжилтийг хариуцах Экосистемийн үйлчилгээний групп томилно. Уг Групп экосистемийн үйлчилгээний чиглэлээр Санхүүжүүлэгчтэй харилцах гол нэгж байна. Групп нь олон улсын биологийн олон янз байдлын байгууллагууд (2 дугаар	Группийг томилж, Санхүүжүүлэгчдэд мэдэгдэх	Дууссан	ЭҮАХ

Biodiversity Action Plan		
Effective Date: 2013.09.01	Document Number: OT-10-E16-PLN-0001-E	Version: 1.3

#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ЭХ БАРИМТ БИЧИГ
		зүйлд тодорхойлсны дагуу), экосистемийн үйлчилгээний талаар шилдэг туршлага хэрэгжүүлж буй бусад мэргэжилтнүүдээс дэмжлэг авч ажиллана.			
	Эрх зүйн хэрэгжилтийн менежмент	ОТ компани БОЯБУАТ, Ургамал, ан амьтны удирдлагын төлөвлөгөө, биологийн олон янз байдалтай холбоотой БОННУ-ний шаардлагуудыг ЭМААБО-ы удирдлагын тогтолцоо, баталгаажуулалтын үйл ажиллагаандаа нэгтгэн оруулна.	Биологийн олон янз байдалтай холбоотой үүрэг амлалтуудыг ЭМААБО-ы удирдлага, баталгаажуулалтын үйл ажиллагаандаа нэгтгэнэ.	Дууссан	БОЯБУАТ, БОЯБХҮТ, ДХУТ, холбогдох журмууд